

ҮАГ-ЫН ГАРГАСАН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАЙЛАН

2018 оны 09 сарын 27

№	Асуудал	Аудитаас өгсөн зөвлөмж	Биелэлт ийн хугацаа	Хариуцах эзэн	Зөвлөмжийн биелэлт	(%)
1	Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн болох санхүүгийн тайлангийн тодруулгыг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна. Энэ нь НББ-ын тухай хуулийн 7 дугаар зүйл, СС-ын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг мөнгөөр илэрхийлнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.	НББ-ийн тухай, Сангийн сайдын 2017 оны 12 сарын 14-ний өдрийн 361 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөж ажиллах	2018.03	Ерөнхий нягтлан бодогч	2017 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг сангийн яамны “E-balance”-д мянган төгрөгөөр тайлагнан хавсаргасан байсныг аудитын явцад залруулан төгрөгөөр илэрхийлж тайланд хавсаргасан болно. Зөвлөмжийг хэрэгжүүлсэн.	100
2	Нийт 23.2 сая төгрөгийг зардлын дансад буруу ангилан тайлагнасан. Үүнээс 16.4 сая төгрөг нь татвар ноогдох орлогоос хасагдахгүй зардал байна. НББ-ын тухай хуулийн 20.2.3-т “холбогдох ОУ-ын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 5.1.4-т заасан үнэн зөв байх гэсэн зарчмыг баримтлан НББ хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэнтэй нийцэхгүй байна.	Зардлын дансыг зөв ангилан, НББ тухай, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмуудыг мөрдөн ажиллах	2018.03	Ерөнхий нягтлан бодогч	Аудитын зөвлөмжийн дагуу зардлын дансанд бичигдсэн ажил гүйлгээг холбогдох зардлын дансанд, мөн 16,4 сая төгрөгийн зардлыг үйл ажиллагааны бус зардлын дансанд аудитын явцад залруулж бүртгэсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлсэн.	100
3	Хандгайт-Төмөртэй чиглэлийн 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих-шилжүүлэх төслийг ЗГ-ын 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 6 тоот тогтоолоор цуцалсан. Гэвч тухайн чиглэлийн төмөр замаар МТЗ ТӨХК 2016 оны 05 дугаар сараас эхлэн тээвэрлэлт хийж эхэлжээ. 2017 онд 2.0 сая тн хүдэр тээвэрлэхээр төлөвлөснөөс 0.7 сая тн хүдэр тээвэрлэж 1,960.6 сая төгрөгийн зардал гарган, 1,798.1 сая төгрөгийн орлого олж 162.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Ганцхан компанийн ачааг тээвэрлэхийн тулд алдагдал хүлээж байгаа нь тус компанийн санхүүгийн тайлангийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.	Өрийн удирдлагын тухай хуулийн 5.1.3-т “өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах”, Компанийн дүрмийн 2.1-т “Компанийн үндсэн зорилт нь иргэн ААН, байгууллагад төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлж, ашгийн төлөө ажиллахад оршино” гэж заасныг мөрдөж ажиллах	2018	Санхүүгийн хэлтэс, Тээврийн хэлтэс, Захиргааны хэлтэс	Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа алдагдалтай ажилласан нь УБТЗ ХНН-ийн зүгээс вагон хангалт захиалсан хэмжээнд хийгдээгүйгээс тээвэрлэлт төлөвлөгөөт хэмжээнд хүрээгүй болон өртөөний үйл ажиллагаанд ашиглаж буй зээлийн хөрөнгөөр авсан 3 зүтгүүрийн элэгдэл болон зээлийн хүүгийн зардалтай холбоотой. Аудитын зөвлөмжийн дагуу тээвэрлэлттэй уялдуулан ажиллагсадыг ажиллуулах, тэвчиж болох зардлыг бууруулах,	100

					тэвэрлэлтийн тарифыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.	
4	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил 2015 оны 2 дугаар сараас Хөгжлийн банкны санхүүжилт зогссонтой холбоотойгоор зогсонги байдалд орсон байна. Улмаар төслийг 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр дуусгавар болгон цуцалжээ. Замын ажил зогссон ч төслийн ажилтнууд одоог хүртэл ажилласаар байгаа ба 2017 онд төслийн ажилчдын жилийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нийт 310.7 сая төгрөг болсон байна. Энэ нь компанийн санхүүгийн тайлангийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж үргүй зардал гарах магадлалтай байна.	ТУЗ болон гүйцэтгэх удирдлага энэ талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.	2018	Санхүүгийн хэлтэс, Захиргааны хэлтэс, Төслийн хэлтэс	Тус компани УИХ болон Засгийн Газрын гаргасан тогтоол, шийдвэрийн дагуу Тавантолгой-Гашуунсухайт, Нарийнсухайт-Шивээхүрэн, Таван толгой-Сайншанд чиглэлийн төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд төслийн явцад бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хариуцах, инженерийн болон санхүүгийн тооцоо, судалгааг хийх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах зэрэг барилгын ажил эхлэхтэй холбоотой бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэж, ТУЗ-ийн баталсан төлөвлөгөөнд тусгагдсан зардлыг гаргаж төслийн өртөгт хуримтлуулан бүртгэдэг. Зардал хэмнэх зорилгоор төслийн ажлын ачаалалтай уялдуулан зарим ажилтныг сул зогсолтонд хамруулж ажиллаж байна.	100
5	2010 онд БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 35.7 сая ам. долларын хөрөнгийг НББ-д тусгаж үйл ажиллагаанд ашиглаж байгаа боловч одоог хүртэл ЗГ-тай зээлийн дамжуулан зээлдүүлэх гэрээ хийгдээгүй байна. Зээл авснаас хойш зээлийн эргэн төлөлт хийгдээгүй одоогоор зээлийн хуримтлагдсан хүүгийн өглөг 9,219.9 сая төгрөг болсон.	ЗГ-тай “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулах	2018.09	Санхүүгийн хэлтэс	Дамжуулан зээлийн гэрээ хийх талаар Сангийн яамтай байнгын холбоотой санал солилцож ажилласанаар гэрээний зээл, хүүгийн эргэн төлөтийн хуваарийг тохиролцож, 9-р сард багтаан ЗТХЯ, Сангийн яам, МТЗ ТӨХК-ын хооронд дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээ байгуулахаар ажиллаж байна.	50
<b>Нийт биелэлт (хувиар)</b>						<b>90%</b>

Танилцсан: Гүйцэтгэх захирал

Б.ЦЭНГЭЛ

СА-ны дарга

Б.Энэрэлт

Тайлагнасан: Ер.нябо

Д.Даваадорж

Хянаж, дүгнэсэн: ДА-ын ажилтан

Д.Болормаа

